Ёс зүйн дэд хорооны 2025 оны
09 дүгээр тогтоолын 1-р хавсралт

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2025 ОНЫ “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0,5	0,5	
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0,5	0,5	
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0,5	0,5	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын маягт бөглөсөн байдал	0,5	0,5	
Хэсгийн оноо				4	4	
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх		1	1	
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	0,5	
Хэсгийн оноо				3	2,5	
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /гомдол ирээгүй бол 1 оноо/		1	1	
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал		1	0,5	
Хэсгийн оноо				3	2,5	
Үнэлгээний нийт оноо, хувь				10	9	

Үндэсний геологийн албаны Ёс зүйн дэд хороо

Ёс зүйн дэд хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
3-р хавсралт

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг. Товч танилцуулга
МУ-ын Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолоор Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаарыг 32 байхаар баталсан. Үүнээс: Төрийн захиргаан албан хаагч 12, Төрийн үйлчилгээний албан хаагч 20 ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 3 гишүүнтэй. Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 3 зорилгын хүрээнд 12 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн байгууллагын даргаар батлуулан хэрэгжүүлсэн.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
• Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолоор Үндэсний геологийн албаны орон тооны дээд хязгаар (32), Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/169 дугаар тушаалаар "Үндэсний геологийн албаны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг тус тус шинэчлэн батлсны дагуу Үндэсний геологийн албаны албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан бөгөөд "Албан тушаалд тавигдах тусгай шаардлага" хэсэгт Ёс зүйн хэм хэмжээ, зарчимч, тууштай байдал, харилцааны соёл, ажил хэрэгч байдал, хувийн зохион байгуулалтаар үлгэрлэх шаардлагыг бүх албан хаагчдын АТТ-д шинэчлэн оруулсан.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
• Албан хаагчдаас нээлттэй авсан сонгон шалгаруулалтын дүнд байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг томилох, төлөвлөгөөг батлах, урамшууллыг олгох ажлыг дэмжиж ажилласан. • 2025 оны 12 дугаар сарын 23-ны байдлаар ёс зүйн аливаа зөрчил гомдол бүртгэгдээгүй.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
• 2025 оны 12 дүгээр сарын 23-ны байдлаар тус албанд ёс зүйтэй холбоотой аливаа гомдол мэдээлэл ирээгүй бөгөөд, зөрчил үүсээгүй. Ёс зүйн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу ёс зүйн дэд хорооны журмыг мөрдлөг болгон дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг гарган 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын удирдлагаар батлуулсан. • Ёс зүйн дэд хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалын дагуу 26 албан хаагч буюу 83 хувийг хамруулж, аргачлалын дагуу үнэлгээ хийсэн. • Удирдлагын академиас зохион байгуулсан "Хөдөлмөрийн харилцаа болон хүний эрх, ёс зүй" сэдэвт сургалтад албан хаагчид 90 хувьтай оролцож, мэдээлэл солилцсон. • Төрийн албан хаагчийн ёс зүй, хувь хүний харилцаа хандлага, авлигын эсрэг хамтдаа сэдэвт сургалтад 2025 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд Үндэсний геологийн албаны 5 албан хаагч оролцсон. • Удирдлагын академийн дэргэдэх төрийн албаны сургуулийн Ёс зүй хүний эрх сэдэвт сургалтад байгууллагын удирдлага Н.Мөнхбилэг, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Шинэ-Од, Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б. Батлхагва нар хамрагдаж давхардсан тоогоор 36 цагийн хичээлд хамрагдаж үнэмлэх авсан.

- Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй болон эрүүл мэнд" сэдэвт сургалтад 8 албан хаагч хамрагдсан.
- ҮГА-ны Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 11 дүгээр сард “Ёс зүй танаас эхэлнэ” сэдэвт сургалтыг зохион байгуулж 26 албан хаагч буюу 83 хувьтай оролцсон.
- Бүх албан хаагчдын дунд харилцааг сайжруулах нөлөөллийн арга хэмжээ болгож “Талархал илэрхийлэх” өдрийг зохион байгуулж албан хаагчид бие биедээ талархал илэрхийлсэн цахим зурвас бичих ажлыг зохион байгуулав. Мөн ажилдаа ирэх болох тарахдаа мэндлэх соёлыг төлөвшүүлэх ажлыг нэгжийн дарга нараас манлайлан эхлүүлсэн.
- Албаны цахим хуудаст Ёс зүйн дэд хороо цэс байршуулж, тайлан мэдээллийг оруулж байна. Абле цахим системийн олон нийтэд мэдээлэх хэсэгт “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх” үндэсний хөтөлбөрийг нийтэд мэдээлж, тогтмол сурталчлан таниулах ажлууд хийгдэж байна.
- Шинээр ажилд орж байгаа 7 албан хаагчаас ёс зүйн төлөвшил, зан үйл, хэв маягийг тодорхойлох сорил авсан.
- 2025.10.31-нд байгууллагын албан хаагчдад Ёс зүйн хорооноос гаргасан тогтоол шийдвэрийг танилцуулж, ёс зүйн талаарх мэдээлэл хүргэсэн.
- 2025 оны 12 дугаар сарын 23-ны байдлаар ёс зүйн аливаа зөрчил гомдол бүртгэгдээгүй.

Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
Иргэд ААН-тэй уулзах хуваарийг албаны даргын тушаалаар баталж, иргэдтэй уулзах тусгай хэсгийг тохижуулан ажиллав. Нийт албан хаагчид ажилдаа ирэх болох тарахдаа харилцсан мэндчилэх соёл бүрэн төлөвшсөн байна. Албан хаагчид утасны дуудлагад хариулах соёлыг төлөвшүүлэхээр ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдаас иргэдэд чиглэсэн үйлчилгээнд хамаарах гомдол ирээгүй.	Төсвийн хэмнэлтийн хүрээнд байгууллагын төсөвт ёс зүйн хорооны үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг. Төсөв дутагдалтай байгаагаас Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 3.8 дэх хэсэгт заасан урамшууллыг бүрэн олгох боломжгүй ажилласан.

Санал:
Байгууллагын албан хаагчдын тоонд уялдуулж жил бүр сургалт, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалт, бусад арга хэмжээнд зориулсан төсөв суулгаж байхыг төсөв баталж байгаа төрийн захиргааны төв байгууллагад Ёс зүйн хорооноос чиглэл өгч биелэлтийг шалгаж байх

Үндэсний геологийн албаны даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхбилэг

Үндэсний геологийн албаны
Ёс зүйн дэд хорооны дарга С.Шинэ-Од

Боловсруулсан: Ёс зүйн дэд хорооны
нарийн бичгийн дарга /Х.Ариунбаяр

2025.12.25

БАТЛАВ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.БАТЦАЦРАЛ

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Зорилго	д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа /улирлаар/				Хариуцах гишүүний нэр	Төсөв
				1	2	3	4		
1	Зорилго-1 Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулна	1	Ёс зүйн дэд хорооны хийх ажлын төлөвлөгөө гаргаж боловсруулан батлуулах					Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Х.Ариунбаяр	
		2	Ёс зүйн хорооны вэб хуудаст албаны ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг тайлагнах					Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Х.Ариунбаяр	
		3	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд сургалт, мэдээлэл хийх					Ёс зүйн дэд хорооны дарга С.Шинэ-Од	
		4	Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар танилцуулга хийх					Ёс зүйн дэд хорооны гишүүн Ч.Төржаргал	
		5	Төрийн албаны тухай хууль, хуулийг дагаж гарсан журам, тогтоолуудын талаар сургалт, мэдээлэл хийх					Ёс зүйн дэд хорооны дарга С.Шинэ-Од	
2	Зорилго-2 Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ.	6	Шинээр ажилд орсон албан хаагчийг ёс зүйн төлөвшил, зан үйл хэв маягийг тодорхойлох сорил авах, чиглүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, танилцуулах					Ёс зүйн дэд хорооны гишүүд, Хүний нөөц сургалт хариуцсан мэргэжилтэн	
		7	Байгууллагын соёлын сэдэвт сургалт зохион байгуулах					Ёс зүйн дэд хорооны гишүүд, Хүний нөөц сургалт хариуцсан мэргэжилтэн	

3	Зорилго-3 Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг сайжруулна.	8	Албаны цахим хуудаст Ёс зүйн цэсийг үүсгэх, мэдээлэл түгээн ажиллах, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад мэдээллийг тогтмол байршуулах					Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Х.Ариунбаяр	
		9	Хамт олны харилцааг сайжруулах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах					Ёс зүйн дэд хорооны гишүүн Ч.Төржаргал	
		10	Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах түүнд гомдол гаргах журмын сургалт мэдээлэл хийх					Ёс зүйн дэд хорооны дарга С.Шинэ-Од	
		11	Ажлын байрны сэтгэл зүйн талаар харилцан яриа зохион байгуулах					Ёс зүйн дэд хорооны гишүүд	
		12	Төрийн албан хаагчдын ёс зүйн тандан судалгааг зохион байгуулах					Ёс зүйн дэд хорооны гишүүд	

Үндэсний геологийн албаны Ёс зүйн дэд хороо